2017 оны 10 дугаар сарын 24 өдөр А/688 Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн нэр шилжүүлэхээр хүсэлт гаргасан 3 /гурав/ иргэний газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэн хавсралтаар баталгаажуулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэн баталгаажуулсан 2015 оны А/495 дугаар захирамжийн Жанцан Сарангэрэл, 2007 оны А/186 захирамжийн Жанцан Энхмөнх, 2015 оны А/495 дугаар захирамжийн Жанцан Отгонцэцэг нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх шилжүүлэн авсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ж.ЭРДЭНЭБАТ